


mobiCARE™


MC200M ГАРЫН АВЛАГА

Хэмжилтийн код үүсгэх (вэб сайт)

Төхөөрөмжийг бэлтгэх, суурилуулах



Хэмжилтийг эхлүүлэх



1. Chrome хөтөчөөр www.seerscardio.com вэбсайт руу хандана
2. Хэрэглэгчийн ID болон нууц үгээ ашиглан нэвтрэнэ
3. Дэлгэцийн баруун дээд өнцөг дээр байрлах **Add** товч дээр дарна
4. Эмчлүүлэгчийн мэдээлэл оруулна (Оруулахгүй байж болно)
5. Хэмжилтийн мэдээлэл оруулна (Заавал оруулна)
6. Ordering Physician буюу Захиалагч эмчийн нэрийг бичнэ
7. Hook Up Technician буюу Холболтын техникч нэрийг бичнэ (Эмч бие даан суурилуулсан бол өөрийн нэрийг бичнэ)
8. Measurement code буюу хэмжилтийн код бичнэ (Өөрөө мэдэн зохиож болох бөгөөд тухайн хэмжилтийн мэдээллийг таньж олоход учир давхцахгүй байх ёстой.)
9. Хэмжилт хийх төхөөрөмжийн сериал дугаарыг бичнэ. (Том А үсгээр эхэлсэн 7 оронтой тоог бичнэ.)
10. Хэмжилт хийх хугацааг оруулна
11. Баруун доод хэсэгт байрлаж буй **Create** товч дарна




1. Пластик онгойлгогчоор баттерейн тагийг авна
2. Баттерейн +(нэмэх) талыг дээш харуулан хийнэ
3. Пластик онгойлгогчоор тагийг хаана
4. Электродыг наалтад суурилуулан Клик гэсэн чимээ гарахыг хүлээнэ
5. Power товч дээр дарж Төхөөрөмжийг асаан ногоон гэрэл 3 удаа анивчах хүлээнэ
6. Эмчлүүлэгчийн арьсыг алкохолтой салфиткар арчиж бэлтгэнэ. Арьс цэвэр, хуурай байх ёстой. Шаардлагатай бол тухайн хэсгийн үсийг хусна.
7. Зураг 1-д заасан байрлалд төхөөрөмжийг суурилуулна
8. Power буюу тэжээлтэй хэсэг дээд хэсэгт баттерейтэй хэсэг доод талд байрлана
9. Эмэгтэй эсвэл том биетэй эмчлүүлэгчид зураг 2-т харуулсан байдлаар суурилуулж болно

1. Хэрэв хэмжилтийн аппликэйшнийг урьдчилан суулгаагүй бол Андроид утас хэрэглэгчид Play Store-с iPhone утас хэрэглэгчид App Store-с "**mobicare cardio hospital**" гэж бичин хайж **mobiCARE Cardio Hospital** аппликэйшнийг гар утасдаа суулгана
2. Вэбсайтад урьдчилан үүсгэсэн Measurement code буюу хэмжилтийн кодыг оруулан **Томруулдаг шилний зурагтай товч** дарна
3. **Confirm and continue** товч дээр дарж үргэлжлүүлнэ
4. Төлөвийг шалгасны дараа **Start the measurement** товч дарна
5. Privacy policy буюу Нууцлалын бодлогыг зөвшөөрсөн зөвшөөрлийг **Agree** товч дарж өгнө
6. ECG мэдээлэл энгийн гарч ирж буй эсэхийг баталгаажуулаад **Finish the app** товч дарна



Хэмжилтийн өгөгдлийг хуулах

1. PC Uploader програмыг урьдчилан суулгаагүй бол www.seerscardio.com вэбсайтаас PC Uploader програмыг татаж авна.
2. www.seerscardio.com вэбсайт руу нэвтэрч дэлгэцийн баруун дээд талд байрлах **PCUploader** товчыг дарж програмыг татан авч суулгана
3. Эмчлүүлэгчээс хэмжилт дууссан дараа төхөөрөмжөө салган авна
4. Төхөөрөмжээс батерейг салгана. Үүний дараа Cradle уншигч төхөөрөмж дээр байршуулж уншигчын компьютерт USB кабелиар холбоно
5. PC Uploader програмыг нээн бүртгэлээрэй нэвтэрсний дараа дэлгэцийн зүүн талд байрших **Upload** товчыг дарна
6. Мэдээлэл дамжуулалт амжилттай дуусах хүртэл Төхөөрөмж, Уншигч, USB кабелийг хөдөлгөлгүй хүлээнэ
7. Мэдээлэл дамжуулалт дууссаны дараагаар Төхөөрөмжийн холболтыг салгана



Тайлан хэвлэх

1. www.seerscardio.com вэбсайтаас тайланг хэвлэнэ
2. Премиум тайлан гарсаны дараагаар **Completed** төлөвтэй болсон байна.
3. Measurement list буюу хэмжилтийн жагсаалтын баруун талд байрлах **Эмчийн зурагтай товч** дарна
4. Final interpretation хэсэгт бичсэний дараагаар **Save** товчыг дарна
5. Signed хэсэгт эмчийн нэрийг бичээд **Save** товчыг дарна
6. Баруун хэсгээс тохирох сонголтыг сонгоно. Тайланг PDF, JPG форматаар татах буюу шууд хэвлэх боломжтой.



- Хэмжилт хийж байх үед MRI, Компьютер томограф, рентген хийлгэж болохгүй
- Цахилгаан халаагчтай хөнжил, гудас хэрэглэж болохгүй
- Хэрэглэгсэн электродыг давтан хэрэглэж болохгүй
- Хэмжилт хийх бүрт төхөөрөмжид шинэ баттерей хэрэглэх ёстой
- Зөвхөн Panasonic CR2450 эсвэл Murata CR2450R баттерейг хэрэглэнэ
- Дээрхээс өөр баттерей хэрэглэвэл хэмжилтийн үеэр унтарч болзошгүй
- Төхөөрөмжийг компьютерт холбохдоо баттерейг заавал салгана
- Төхөөрөмжийг эмчлүүлэгчид суурилуулахаас өмнө электродтой холбосон байх ёстой
- Төхөөрөмжийг аппликэйшнтэй холбохдоо Finish the App товч гарч ирэх хүртэл хүлээнэ
- Finish the App товч дарсаны дараа төхөөрөмжийг дахин холбож аппликэйшнтэй дахин холбож болохгүй
- Илүү мэдээллийг YouTube-с mobiCARE MC200M түлхүүр үгээр хайн үзэх боломжтой
- **Event товч**
Цээжээр өвдөх, толгой эргэх, зүрх дэлсэх зэрэг шинж тэмдэгийг бичихийн тулд Power товчийг дарна. Төхөөрөмжийг нэгэнт асаасны дараа power товчыг даран унтраах боломжгүй
- **Хэмжилтийн үеэр LED гэрэл**
Хэмжилт амжилттай эхлэхэд LED гэрэл унтрана. Товчыг дарахад LED гэрэл ногооноор анивчина
- **LED гэрэл улаанаар анивчих үед яах вэ**
Төхөөрөмж ECG хэмжилтийн сигналыг сайн хүлээж авахгүй байна гэсэн үг юм. (төхөөрөмж тогтоогдоогүй эсвэл муу тогтоогдсон байж болно)
- **LED гэрэл улаанаар асах (анивчихгүй) үед яах вэ**
Энэ нь төхөөрөмжийн санах ойн хэвийн бүс ажиллагааг илтгэдэг. (санах ойг суулгаагүй эсвэл холболтын алдаа гарсан байж болно)

ХОЛБОО БАРИХ

Утас: 9927 2701, 7015 7090
Имэйл: hatnaa@tuulanjin.com